



СҮХБААТАР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2017 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 02

Баруун-Урт

Г Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл  
ажиллагааны хөтөлбөрийг батлах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх хэсгийн “д”, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын ээлжит 3 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засаг дарга /З.Энхтөр/-д үүрэг болгосугай.

1. Үйл ажиллагааны хөтөлбөрийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж ажиллах.
2. Жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг үе шаттайгаар оновчтой тусган хэрэгжүүлэх.
3. Төсөв, санхүүгийн хувиарлалтыг зөв зохистой зохион байгуулж, төлөөлөгчдөөс зөвшөөрөгдсөн саналуудыг үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.

ДАРГА



Б.ГАНСҮХ